

ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК

Огноо: **2019.02.24**

**[ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ, ТОХИЖИЛТЫН МАТЕРИАЛ] НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Тендерийн урилга дугаар: ХӨАДСТӨХК/201901020

Мөрөн сум 2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ, ТОХИЖИЛТЫН МАТЕРИАЛ**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 ОНЫ 03-Р САРЫН 04-НЫ ӨДРИЙН 10 ЦАГ 00 МИНУТ**-аас өмнө **ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ОФФИС, СБ ТӨВИЙН 4 ДАВХАР 406 ТООТ** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 ОНЫ 03-Р САРЫН 04-НЫ ӨДРИЙН 10 ЦАГ 10 МИНУТАНД** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх-ҮГҮЙ

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ОФФИС, СБ ТӨВИЙН 4 ДАВХАР 406 ТООТ
ХАРИЛЦАХ УТАС: 70388489, 99040355**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн 1 туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: шаардахгүй</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: ХӨВСГӨЛ АЙМАГ МӨРӨН СУМ ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ТӨВ ОФФИС СВ ТӨВ</p> <p>Давхар болон ерөөний дугаар: ЦАХИМ</p> <p>Огноо: 2019 ОНЫ 03-Р САРЫН 04-НЫ ӨДӨР</p> <p>Цаг: 10 ЦАГ 00 МИНУТ</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: ХӨВСГӨЛ АЙМАГ МӨРӨН СУМ ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ТӨВ ОФФИС СВ ТӨВ</p> <p>Давхар болон ерөөний дугаар: ЦАХИМ</p> <p>Огноо: 2019 ОНЫ 03-Р САРЫН 04-НЫ ӨДӨР</p> <p>Цаг: 10 ЦАГ 10 МИНУТ</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: БАИХГҮЙ</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт: [Барааны тодорхойлолт, техникийн үзүүлэлтийг энд бичнэ.]

Хувийн хамгаалах хэрэгсэл, тохижилтын материалын техникийн шаардлага

№	Хөдөлмөр хамгааллын зүйлс	Хэмжих нэгж	Холбогдох стандарт	Тодорхойлолт
Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл				
1	Каска	ш	MNS5621:2006	Толгой хамгаалах дуулга. Толгой дээр гадны биед унахад толгойг хамгаалахаас гадна хөлс зайлуулах агааржуулагчтай байна. ММ-механик үйлчлэл, 400-1000В цахилгаан хүчдэл, -50аас +150 хэмийн температурт ашиглах боломжтой. Өнгө: Шар, цагаан, хөх
2	Бээлий /алгатай/	хос		хуруутай, Нитрил бээлий, үнэргүй, даавуун материалтай
3	Бээлий /энгийн/	хос		хуруутай, алгандаа цэгтэй, даавуун материалтай,
4	хошуувч /нэг удаагийн/	ш		солонгос, хавлагатай, харшил өгөхгүй, тоос шүүгч давхарга 4 ба түүнээс дээш, хамрын хянганы даруулга төмөр тохируулагчтай байх, толгойд бэхлэх резинэн уяатай
5	Шүүлтүүртэй хошуувч	ш	MNS5620:2006	химийн бодистой харьцаж ажиллах үед хэрэглэх, фильтр солидог, зүүхэд эвтэйхэн
6	нүдний шил	ш	MNS5389:2004	хөнгөн, арьсанд харшил өгөхгүй, PVC материалаар хийсэн, зурагдалт бага, зүүхэд эвтэйхэн, хамрын өндөрт тохирсон
7	Саван	ш		хуурайшуулахгүй, чанартай
8	чихний бөглөө	ш	MNS5388:2004	чихэнд сөрөг нөлөөгүй, чихний сувгийг цочроохгүй, бөглөө нь полиуретанаар хийгдсэн агших тэлэх чадвартай хөвсгөр байна. Хоорондоо уян холбоогоор холбогдсон, шуугианыг 30Дб-ээс багагүй хэмжээгээр бууруулах чадвартай
9	чихэвч	ш	MNS5388:2004	Хамгаалалтын малгай + чихэвч. Полиэтилен болон полимер материалаар хийгдсэн байх ба хөлс шингээх чадвартай, толгойд босоо тэнхлэгийн дагуу тохируулах боломжтой, чихэвч нь хоорондоо уян холбоогоор холбогдож, чихний дээр хөдөлгөөнгүй шуугиан нэвтрэх зайгүйгээр сууж байх, шуугианыг 35Дб-ээс багагүй хэмжээгээр бууруулах чадвартай байх
10	нүүрэвч	ш		Тасдагч, зүлгүүр ашиглах ашиглах зориулалттай, пластик материал хийгдсэн, зурагдах, зүсэхдэхээс хамгаалагдсан
11	гагнуурын баг	ш		бууралттай материалаар хийгдсэн, гагнуур хийх үед нүд хамгаалах зориулалттай
12	гагнуурын бээлий	хос		шатахгүй материалаар хийгдсэн, тохой хүртэлх урттай, арьсан материалаар хийгдсэн
13	нэг удаагийн бээлий	боодол		шохойгүй, резинэн 1 удаагийн бээлий, химийн лабораторт ашиглах боломжтой
14	бээлий	ш		хүчил шүлтэд тэсвэртэй
15	цув	ш		ОХУ /опу/ цувтай дүйцэхүйц, бүтэн өмсдөг, гуталтай
16	усны гутал	ш	MNS5623:2006	ус чийгнээс хөл хамгаалах гутал нь шахмал резинэн материалаар ул болон түрийг оёдолгүй хийсэн байна. Ул нь зуурамтгай нугаралт үүсэхгүй
Дүн				
Танхимын тохижилтын материал				
17	Проектор /таазны/	ш		таазанд бэхлэх зориулалттай /чанартай/
18	самбар	ш		жижиг, зөөврийн хөлтэй самбар
19	Муляж	ш		Зүрхний иллэгийн хурд болон даралтыг тодорхойлдог индикатортай, угааж цэвэрлэдэг арьстай, амьсгалын замыг чөлөөлөх механизмаар тоноглогдсон.
20	Орчны үзүүлэлт хэмжих багаж /4 үзүүлэлт/	ш		Дуу чимээ, Гэрэлтүүлэг, Температур, Чийгшил хэмжих багаж
21	Жин	ш		баталгаажсан жин
22	Даралтны аппарат /зөөврийн/	ш		электрон, овор хэмжээ багатай, баталгаажуулсан
23	Сэтгүүлийн тавиур /ШУК өрөө/	ш		сонин, сэтгүүл тавих зориулалттай

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа					
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа			
1	2	3	4	5	6	7	8			
1	Каска	100	ш	ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХЖ- ИЙН СТАНЦ	ГЭРЭЭ БАЙГУУЛСА Н ӨДРӨӨС 14 ХОНОГИЙН ДОТОР	2019 ОНЫ 12- ДУГААР САРЫН 10				
2	Бээлий /алгатай/	1668	хос							
3	Бээлий /энгийн/	1949	хос							
4	хошуувч	6183	ш							
5	хошуувч /тусгай/	5	ш							
6	нүдний шил	1053	ш							
7	Саван	2033	ш							
8	чихний бөглөө	1359	ш							
9	чихэвч	20	ш							
10	нүүрэвч	28	ш							
11	гагнуурын баг	8	ш							
12	гагнуурын бээлий	54	хос							
13	нэг удаагийн бээлий	20	боодол							
14	Хүчил, шүлтэд тэсвэртэй бээлий	12	ш							
15	цув	4	ш							
16	усны гутал	6	ш							
Дүн										
Танхимын тохижилтын материал										
17	Проектор /таазны/	1	ш							
18	самбар	2	ш							
19	Муляж	1	ш							
20	Орчны үзүүлэлт хэмжих багаж /4	1	ш							
21	Жин	1	ш							
22	Даралтны аппарат /зөөврийн/	2	ш							
23	Сэтгүүлийн тавиур /ШУК өрөө/	2	ш							

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[2019.03.04]

ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ын дарга Ч.ЦОГОО танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|----------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулсан холбогдох баримт бичиг |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [ЗААХГҮИ] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [14 ХОНОГ] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
[ШААРДАХГҮЙ] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн [50]¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² | <p>9.1. Алданги оногдуулах хувь: [0.5]</p> <p>Алдангийн нийт дүн: [10%]</p> |

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]